



ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХУГАЦАА: 2025 -2028 ОН

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Харилцах утас:
7773-3153

<https://hhaag.erdnet.mn/>

Пэйж:
Орхон аймаг.
Хүнс, Хөдөө Аж
Ахуйн газар

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах хууль эрх зүйн үндэслэл	3
1.2 Стратеги төлөвлөгөөний зорилго	3
1.3 Стратеги төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим	3
1.4 Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ	4
1.5 Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн	4

Хоёр. Мандатын шинжилгээ

2.1. Мандатын шинжилгээ хийх үе шат	4
2.2. Байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээ	5
2.3. Хүнс, хөдөө аж ахуйн газрын чиг үүргийн хуваарилалт	14

Гурав. Алсын хараа

3.1. Алсын хараа	21
------------------	----

Дөрөв. Эрхэм зорилго

4.1. Эрхэм зорилго	21
4.2. Үнэт зүйл	21
4.3. Стратегийн тэргүүлэх чиглэл	21

Тав. Орчны шинжилгээ

5.1. Салбарын хүний нөөц	22
5.2. Санхүүгийн нөөц	23
5.3. Мэдээллийн болон технологийн нөөц	23
5.4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	24
5.5. Оролцогчдын шинжилгээ	25

Зургаа. Свот шинжилгээ

6.1. Мал аж ахуйн салбарын SWOT шинжилгээ	26
6.2. Газар тариалангийн салбарын SWOT шинжилгээ	27
6.3. Хүнсний салбарын SWOT шинжилгээ	27
6.4. Хөнгөн үйлдвэрийн салбарын SWOT шинжилгээ	27
6.5. Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын SWOT шинжилгээ	28
6.6. Хүнсний хяналтын SWOT шинжилгээ	28

Долоо. Стратегийн зорилго

28

Найм. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

30

**Ес. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын
холбогдогч талуудын оролцоо**

9.1. Холбогдогч талуудын оролцоо	34
9.2. Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц, зохион байгуулалт	35
9.3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжийн матриц	36

Арав. Стратеги төлөвлөгөөний төсөв, эх үүсвэр	41
--	-----------

Арван нэг. Хүнс, хөдөө аж ахуйн газрын стратеги төлөвлөгөө /2025-2028 он /	43
---	-----------

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах хууль эрх зүйн үндэслэл:

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын “Стратеги төлөвлөгөө”-г Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны “Алсын хараа-2050”, “МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоол, 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоол, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгавар, Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, Орхон аймгийн хөгжлийн 2024-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын 2024 оны 03/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн боловсрууллаа. Стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулсан.

1.2. Стратеги төлөвлөгөөний зорилго:

Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хэтийн зорилго, 2025-2028 онд хэрэгжүүлэх стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тогтооход оршино.

Стратегийн зорилт, арга хэмжээ, үндсэн чиглэлийг тогтоохдоо дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Орхон аймгийн хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ, хөнгөн болон жижиг дунд үйлдвэрлэл, мал аж ахуйн өнөөгийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий болон үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
- Орхон аймгийн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул талыг эрэмбэлэх;
- Салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлж, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлах;
- Стратегийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Салбарын стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт үнэлгээ/ боловсруулах;
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдааг тодорхойлох.

1.3. Стратеги төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим:

- Зорилт, арга хэмжээ нь нөөцийг хэмнэлттэй үр ашигтай, зохистой ашиглах.
- Үйл ажиллагааны чиг үүрэг, үр дүнг үндэслэн салбарын бодлого, төлөвлөлтийг тодорхойлох.
- Цахимжуулалт болон бусад дэвшилтэд технологийг дэмжих.

- Бодлогын залгамж чанарыг хадгалсан, нэгдмэл, харилцан уялдаатай байх;
- Үйл ажиллагаа болон чанарын өсөлтийг бий болгоход иргэдийн оролцоог хангах.
- Төлөвлөгөөний зорилт арга хэмжээг хэрэгжүүлснээр гарах үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх.

- Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, судалгаа шинжилгээнд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх.

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх.

1.4. Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас баримтлах бодлого, зорилт, Орхон аймгийн хөдөө аж ахуйн салбарын чиг үүрэгт хамаарах газар тариалангийн салбар, мал аж ахуйн салбар, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоодын хөгжил, хөнгөн үйлдвэрийн салбар, жижиг, дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийн уялдааг хангаж, бодлогыг нэгдмэл байдлаар 2025-2028 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлов.

1.5. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн:

Тус стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, эдийн засгийг тогтвортой өсгөх, үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжилд эерэг нөлөө үзүүлж, өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, аймаг болон бүсийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилт хангагдана.
- Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тэдгээрийг тогтвортой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.
- Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглаж, хамгаалан, нөхөн сэргээж, усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлж, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулан, хамгаалж, ургамал хамгааллын цогц арга хэмжээ хэрэгжсэн байна.
- Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалж, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулна.
- Салбарын үйлдвэрлэлд шинэ, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, техникийн шинэчлэлийн үр дүнд бүтээгдэхүүний гарц, чанар сайжирсан байна.
- Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэл нэмэгдэнэ.
- Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, шим тэжээлийн зохистой хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал хангагдах нөхцөл нэмэгдсэн байна.
- Мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан, шуурхай, ил тод байдлыг хангаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлсэн байна.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

2.1. Мандатын шинжилгээ хийх үе шат:

Мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль болон хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон жижиг дунд үйлдвэрийн салбарт шууд хамаарах 38 хууль, Олон Улсын гэрээ конвенц, төрийн алба, яам, агентлагийн эрхлэх асуудал, төсөв санхүү зэрэг нийт 67 хуулийн хүрээнд хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзэж, дараах шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

2.2. Байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээ

№	Хуулийн нэр	Зорилт, заалт, хэсэг	Агуулга	Батлагдсан он
Нэг. Бодлого, төлөвлөлтийн үндэслэл				
1.	Монгол улсын Үндсэн хууль	62.1.	Улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна	1992
2.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	67.5.	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.	2020
3.	Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль	7.2.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нар удирдана	2020
4.		8.2.	Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны төв байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, сан, Хөгжлийн банк, төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд	

			холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно	
5.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай	2.5.1.	хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана.	2020
		2.5.5.	хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.	
		4.2.2.	хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	
		4.5.2.	бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	
		8.3.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:	
6.	УИХ-ын 2020 оны “Алсын хараа-2050”, “МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоол	2.5.	Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.	2020
		4.2.	Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.	
		4.5.	Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	
		8.3.	Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.	

7.	Шинэ сэргэлтийн бодлого	3.4.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2021
		3.5.	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	
		3.6.	Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.	
		4.4.	Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.	
		5.4.	5.4.Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.	
8.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	1.3.1.4.	Бүс нутгийн онцлогт тохирсон мал үржүүлэг, үржлийн цөм сүрэг бий болгож, орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логиستيкийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.	2024
		2.4.2.	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	

		3.3.4.	Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр	
		3.4.3.6.	Генийн санг хамгаалах, түүнийг баяжуулах биотехнологийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг бодлогоор дэмжинэ.	
		3.3.4.26.	Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулна.	
Хоёр. Мал аж ахуй				
9.	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай	7 дугаар зүйл	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээ	2024
		8 дугаар зүйл	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ	
10.	Малчны тухай хууль	Бүхэлдээ		2024
11.	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	Бүхэлдээ		2024
12.	Малын генетик нөөцийн тухай	Бүхэлдээ		2017
13.	Малын индексжүүлсэн даатгалын тухай	6 дугаар зүйл	Сумын малын хорогдлыг тогтоох, мэдээлэх	2014
14.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	7.1.4	бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах.	2012
		7.3.2	Аймаг дундын отрын бэлчээрийн болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн газрыг хуваарьтай сэлгэн ашиглах;	
Гурав. Газар тариалан				
15.	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай	Бүхэлдээ		2024
16.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	1 дүгээр зүйл	Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний	2024

			хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.	
17.	Таримал ургамлын үр сортын тухай хууль	Бүхэлдээ		2021
18.	Тариалангийн тухай хууль	21.3.	Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тариалан эрхлэгчдийн саналд тулгуурлан боловсруулж, сум, дүүрэг тус бүрээр баталж, хэрэгжилтийг зохион байгуулна /бүхэлдээ/	2016
19.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	7.1.1.	тариалангийн газрын хөрсний үржил шимийг дээшлүүлэх, хөрс хамгаалах техник, технологийг нэвтрүүлэх;	2012
		7.1.2.	цомхотгосон болон элдэншүүлээгүй тэг технологи ашиглахаас бусад тохиолдолд 100 га-гаас дээш талбайд үр тарианы тариалалтын үйл ажиллагаа явуулахдаа зурваслан тариалалт хийх	
		10.1.1.	тариалангийн газар эзэмшигч, ашиглагч нь хөрсний үржил шимийг анхны үзүүлэлтээс сайжруулсан;	
		10.1.2.	тариалангийн газрын эргэн тойронд ойн зурвас байгуулсан, жимс, жимсгэний мод тариалсан, үржүүлсэн, хашаалсан;	
Дөрөв. Хүнсний үйлдвэрлэл				
20.	Органик бүтээгдэхүүний тухай /Шинэчилсэн найруулга/	Бүхэлдээ		2024
21.	Хүнсний тухай хууль	5.3	Эрүүл мэндийн сайдын баталсан зохист хэмжээг үндэслэн хүн амын хүнсний хангамжийг тодорхойлно.	2012
		5.4	Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	

		6.3, 6.5	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	
22.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	Бүхэлдээ		2012
Тав.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо				
23.	Хоршооны тухай хууль	Бүхэлдээ		2020
24.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль	Бүхэлдээ		2019
25.	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	9.1.4.	уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.	2012
26.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	1 дүгээр зүйл	Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.	2005
Зургаа. Хяналт, шалгалт				
27.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай	7-13, 17-24, 29 дүгээр зүйл	Хязгаарлалт, хориглох, тавигдах шаардлага, үйлдвэрлэх, худалдан борлуулахтай холбогдсон харилцаа	2023
28.	Зөвшөөрлийн тухай	4.1.	Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага	2022
		6.2.	Зөвшөөрлийг хүчингүй болгох	
		9.1.6.	Энэ хуулийн хэрэгжилт болон зөвшөөрөл шинээр бий болгох, олгох	

			үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмжийг гаргуулах зорилгоор тусгай мэдлэг, мэргэшил шаардагдах асуудлаар туслалцаа үзүүлэх шинжээч, мэргэжилтнийг татан оролцуулж болно.	
29.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай	4 дүгээр бүлэг	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хориглох зүйл, тавих хяналт	2019
30.	Баяжуулсан хүнсний тухай	11 дүгээр зүйл	Баяжуулсан хүнсэнд тавих төрийн хяналт	2018
31.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай	27.2.1	Стандарт, техникийн зохицуулалтад тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах	2017
32.	Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль	2 дугаар бүлэг	Зориулалтын бүтээгдэхүүний найрлага, сав баглаа боодол, шошгод тавих шаардлага, хориглох зүйл	2017
		18 дугаар зүйл	Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	
33.	Зөрчлийн тухай хууль	3 дугаар бүлэг	Салбарын хүрээнд	2017
34.	Эрүүл ахуйн тухай	7 дугаар зүйл	Үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих эрүүл ахуйн шаардлага	2016
		8 дугаар зүйл	Түүхий эд, бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлд тавих эрүүл ахуйн шаардлага	
		11 дүгээр зүйл	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	
35.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	Бүхэлдээ		2012
36.	Химийн хорт болон аюултай бодисын тухай	18.1.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,	2006

			хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.	
37.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	7 дугаар зүйл	Барааны талаар мэдээлэл авах хэрэглэгчийн эрх	2003
38.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	Бүхэлдээ		2003
Долоо. Төсөв санхүү				
39.	Төсвийн тухай хууль	Бүхэлдээ		2011
40.	Шилэн дансны тухай хууль	Бүхэлдээ		2014
41.	Татварын ерөнхий хууль	Бүхэлдээ		2019
42.	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	Бүхэлдээ		2019
43.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	Бүхэлдээ		2023
44.	Нийгмийн даатгалын тухай хууль	Бүхэлдээ		2023
45.	Цахим гарын үсгийн тухай	2 дугаар бүлэг	Цахим гарын үсэг хэрэглэх	2021
Найм. Нийтлэг мөрдөгдөж буй хуулиуд				
46.	Шинжлэх ухаан, технологийн тухай	13.2.6.	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2024
47.	Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	13 дугаар зүйл	Төрийн байгууллагатай хамтран ажиллах	2024
48.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Бүхэлдээ		2022
49.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Бүхэлдээ		2021
50.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	Бүхэлдээ		2021
51.	Кибир аюулгүй байдлын тухай хууль	16 дугаар зүйл	Төрийн өмчит хуулийн этгээд	2021

52.	Хөдөлмөрийн тухай	Бүхэлдээ		2021
53.	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай	9 дүгээр зүйл	Нийтлэг үүрэг	2021
54.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	Бүхэлдээ		2020
55.	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль	5.3.5.	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	2019
		16 дугаар зүйл	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	
56.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	3 дугаар бүлэг	Хуулийн этгээдийн хувийн хэрэг	2018
57.	Гамшгаас хамгаалах тухай хууль	Бүхэлдээ		2017
58.	Инновацын тухай хууль	2 дугаар бүлэг	Инновацын үйл ажиллагааны удирдлага, төрийн байгууллагын бүрэн эрх	2012
59.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Бүхэлдээ		2012
60.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	Бүхэлдээ		2008
61.	Авлигын эсрэг хууль	Бүхэлдээ		2006
62.	Тамхины хяналтын тухай	5 дугаар зүйл	Тамхины хяналтын талаар төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг	2005
63.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	5 дугаар зүйл	Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үүрэг	2004
64.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай	19 дүгээр зүйл	Нутгийн захиргааны байгууллагатай харилцах	2004
65.	Байгууллагын нууцын тухай хууль	Бүхэлдээ		1995
66.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн	4 дүгээр хэсэг	Байгууллагын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ	2005

	байгууллагын 155 дугаар конвенц			
67.	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын киотогийн протокол	2 дугаар зүйлийн III-т	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлоготой уялдуулан хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн хэлбэрүүдийг хөхиүлэн дэмжих,	1999
68.	Төрийн албаны тухай хууль	Бүхэлдээ		2017
69.	Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль	Бүхэлдээ		2004

Мандатын шинжилгээний үр дүнд 10 ерөнхий чиг үүрэг, 13 үндсэн чиг үүрэг, 71 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэсэн.

2.3. Хүнс, хөдөө аж ахуйн газрын чиг үүргийн хуваарилалт:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		67
үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	38
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	29
Ерөнхий чиг үүрэг-1: Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт		
Үндсэн чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Салбарын хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах;	1.Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах;	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон түүний дэргэдэх байгууллагууд.
	2.Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг хангах;	
	3.Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хангах;	
	4.Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хангах;	
	5.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг хангах;	
	6.Дотоод худалдаа, үйлчилгээний салбарын бодлогын хэрэгжилтийг хангах;	

	7.Шинжлэх ухаан технологи, инновацын бодлогын хэрэгжилтийг хангах;	
	8.Салбарын эдийн засгийн судалгаа, дүн шинжилгээ хийх;	
	9.Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хөтөлбөр, төсөл;	
	10.Салбарын нэгдсэн мэдээллийн сангийн асуудал;	
	11.Мэдээллийн технологи, сүлжээ;	
	12.Салбарын статистик, мэдээлэл, судалгаа;	
Ерөнхий чиг үүрэг-2: Захиргаа удирдлагын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Төрийн захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, аймгийн хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөмжөөр хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг гаргах, олон нийттэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах;	1.Салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хариуцах;	- Хүнс, хөдөө аж ахуйн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, нутгийн захиргааны байгууллага болон түүний дэргэдэх байгууллагууд.
	2.Хүний нөөц, сургалт хариуцах;	
	3.Тогтоол шийдвэрийн биелэлт, дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцах;	
	4.Шагнал, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хариуцах;	
	5.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хэрэглэгчийн үнэлгээг хариуцах;	
	6.Байгууллагын архив-албан хэрэг хөтлөлтийг хариуцах асуудал;	
	7.Байгууллагын төсөв, санхүү, мэдээллийн ил тод байдлыг хариуцах;	
	8.Дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцах;	
Ерөнхий чиг үүрэг-3: Мал аж ахуйн салбарын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид

ҮЧҮ 1: Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж, малын генетик нөөц, үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль, цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчдын орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, малын үржил, селекц, генетик нөөцтэй холбоотой бодлого, стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах;	1.Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудал;	- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; - Малын удмын сангийн Үндэсний төв; - Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа; - Хөдөө аж ахуйг дэмжих сан; - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн; - Аймгийн Засаг даргын Тамгын газар; - Аймгийн Мал эмнэлгийн газар; - Сумдын Засаг даргын Тамгын газар; - Сумдын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгууллагууд;
	2.Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн асуудал;	
	3.Малын тэжээл хангамж, үйлдвэрлэл, нөөцийн асуудал;	
	4.Уур амьсгалын өөрчлөлт, гэнэтийн аюул, эрсдэлийн нөлөөллийг бууруулах асуудал;	
	5.Малчдын хөгжлийн асуудал	
	6.Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах асуудал;	
	7.Малыг бүртгэх системийн хэрэгжилтийг хангах;	
	8.Малын үржил селекцийн бодлого, технологийн ажил, үйлчилгээний хяналтын асуудал;	
	9.Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэх асуудал;	
	10.Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах үйл ажиллагааны зохицуулалт, технологийн хяналтын асуудал;	
	11.Малыг ялган тэмдэглэх бүртгэлжүүлэх;	
	12.Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ, тайлан, технологийн хяналтын асуудал;	
	13.Бэлчээрийн ургамал хамгаалал, нөхөн сэргээлтийн асуудал;	
	14.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;	

Ерөнхий чиг үүрэг-4: Газар тариалангийн салбарын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Газар тариалангийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Газар тариалангийн үйлдвэрлэлийн байгаль, цаг агаарын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, үр, сортын шинэчлэл, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, таримал	1.Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын үйлдвэрлэл, хангамж;	-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; -Аймгийн Засаг даргын Тамгын газар; -Сумдын Засаг даргын Тамгын газар;
	2.Газар тариалангийн техникийн хангамж, ашиглалт, засвар үйлчилгээ;	
	3.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, усалгааны техник технологийг нэвтрүүлэх;	

ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн тогтвортой, хүртээмжтэй хангамжийг бий болгох тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэн тогтвортой хөгжлийг хангах;	4.Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлэх замаар хүнсний нарийн ногооны импортын хэмжээг бууруулах;	- Хөдөө аж ахуйн корпораци; -Ургамал, газар тариалангийн хүрээлэн; -Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн;
Ерөнхий чиг үүрэг-5: Хүнсний үйлдвэрлэл, хангамжийн чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Хүнс болон хоол үйлдвэрлэлд кластерын сүлжээг хөгжүүлэх, хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох, экспортлох боломжийг нэмэгдүүлэх, аймгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх, мэдээллийн цахим санд мэдээлэх;	1.Хүнсний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах	- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - Аймгийн Засаг даргын Тамгын газар; - Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс; - Аймгийн Эрүүл мэндийн газар; - Аймгийн Мал эмнэлгийн газар; - Сумдын Засаг даргын Тамгын газар; - Сумдын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн холбоод; - Төрийн бус байгууллагууд; - Хүнсний үйлдвэрүүд; - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид; - Худалдаа эрхлэгч, аж ахуй нэгж;
	2. Хүнсний сүлжээний бүх үе шатад хүнсний аюулгүй байдлыг хангах	
	3.Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах	
	4.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал;	
	5.Хүнсний худалдааны салбарын зохицуулалт	
Ерөнхий чиг үүрэг-6: Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Хөнгөн үйлдвэрийн салбарт бодлогын хэрэгжилтийг хангаж, экспортын баримжаатай	1.Хөнгөн үйлдвэрийн салбарын санхүү, хөрөнгө оруулалтын асуудал, хүний нөөцийн судалгаа;	- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, кластерын сүлжээг хөгжүүлэх, хөнгөн үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;	2. Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын техник, технологийн шинэчлэлт, кластер үйлдвэрийг хөгжүүлэх;	- Аймгийн Засаг даргын Тамгын газар; - Сумдын Засаг даргын Тамгын газар; - Сумдын Хөдөө аж ахуйн тасаг; - Мэргэжлийн сургалтын байгууллагууд - Мэргэжлийн холбоод; - Хөнгөн үйлдвэрүүд; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгууллагууд;
Ерөнхий чиг үүрэг-7: Жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ, хоршооны салбарын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;	1.Ахуйн үйлчилгээний салбарын хүний нөөц, мэргэжлийн зэрэг, ур чадварыг нэмэгдүүлэх;	- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; -Жижиг, дунд үйлдвэрийн газар; - Аймгийн Засаг даргын Тамгын газар; - Сумдын Засаг даргын Тамгын газар; - Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; - Олон Улсын байгууллагууд;
	2.Ахуйн үйлчилгээний стандарт хангуулах;	
	3.Ахуйн үйлчилгээний судалгаа, бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, хөгжүүлэх;	
ҮЧҮ 2: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;	4.Жижиг, дунд үйлдвэрийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх;	
	5.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн судалгаа, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;	
	6.Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалтыг дэмжих;	
ҮЧҮ 3: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын санхүүгийн бус дэмжлэгийн бодлого, хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;	7.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах;	
	8.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл олгох;	
	9.Сургалт, үзэсгэлэн худалдаанд хамруулах, туршлага судлуулах;	

ҮЧҮ 4: Хоршооны салбарын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;	10. Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг сайжруулах	
	11.Хоршооны хөгжлийг дэмжих;	
	12.Хоршооны хүний нөөцийг чадавхжуулах;	
	13.Хоршооны судалгаа, бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;	
Ерөнхий чиг үүрэг-8: Санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Санхүү, төсвийн зохион байгуулалт хариуцсан нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Байгууллагын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх;	1.Төсвийг хөрөнгө оруулалт, зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөх;	- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар;
	2.Авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;	- Аймгийн Засаг даргын Тамгын газар;
	3.Төсвийг үр ашигтай захиран зарцуулах;	- Аймгийн Мал эмнэлгийн газар
	4.Санхүүгийн тайлан, шилэн дансны болон бусад холбогдох тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах;	- Сумдын Засаг даргын Тамгын газар;
	5. Хөрөнгийн бүртгэл, тооллого, баримт бүрдүүлэлтийг хөтлөх;	- Сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд;
	6. Санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангах;	- Сумдын Хөдөө аж ахуйн тасаг;
		- Мэргэжлийн холбоод;
		- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч;
		- Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж;
		- Хоршоо;
		- Төрийн бус байгууллагууд;
Ерөнхий чиг үүрэг-9: Хяналт, шалгалтын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хүнсний аюулгүй байдлыг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавих нэгжийн үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Жил бүр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хүн амыг аюулгүй хүнсээр хангах сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	1.Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний сүлжээний бүх үе шатанд хяналт тавьж ажиллах;	- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газар;
	2.Нийтийг хамарсан баяр ёслол, өргөдөл гомдол, цаг үеийн шаардлагаар урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх;	- Аймгийн Засаг даргын Тамгын газар;
		- Сумдын Засаг даргын Тамгын газар;

	3.Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарын мэдлэгийг дээшлүүлэх;	- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж;
Ерөнхий чиг үүрэг-10: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр		
Үндсэн чиг үүрэг: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцах нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг:	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ 1: Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, биелэлтийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн удирдлагаар хангах, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;	1.Салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;	- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
	2.Салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;	- Аймгийн Засаг даргын Тамгын газар; - Сумдын Засаг даргын Тамгын газар;
	3.Төсөл хөтөлбөр, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтад дотоод хяналт хийж, дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн удирдлагаар хангах;	- Мэргэжлийн холбоод; - Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч; - Үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуй нэгж; - Хоршоо; - Төрийн бус байгууллагууд; Олон Улсын байгууллагууд;

Монгол Улсын Их хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, Орхон аймгийн хөгжлийн 2024-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлж, байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг бодлогын уялдааг хангахуйц, хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн зорилт, үйл ажиллагааг агуулсан, хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байдлаар тодорхойллоо.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

3.1. Алсын хараа

Байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

4.1. Эрхэм зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, бүтээмжийг өсгөж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

4.2 Үнэт зүйл:

Иргэн төвтэй байх	Иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дээдлэх, тэдний дуу хоолойг сонсох;
Тэгш шударга байх	Нийтийн эрх ашгийг эрхэмлэх, иргэдийг хөгжлөөс хоцроохгүй байх адил тэгш боломжоор хангах;
Ил тод байх	Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх;
Хууль дээдлэх	Үйл ажиллагаандаа хуулийг сахин биелүүлэх, хэрэглэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нөлөөнд автахгүй байх;
Мэргэшсэн, хариуцлагатай байх	Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чадмаг, сурамгай, найдвартай гүйцэтгэх, хариуцсан ажилдаа эзэн байх;
Мэдлэг, инновацыг эрхэмлэх	Асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгаа нь шинжлэх ухаанч, шинэ санаа, технологийн дэвшилтэд шийдэлд тулгуурласан байх.
Хамтын манлайлал	Тодорхой чиг үүргийг хамаарал бүхий талуудын бүрэн оролцоотой зохион байгуулж, хүн бүрийн хүчин чармайлтад тулгуурлан үр дүнтэй хэрэгжүүлэх.

4.3. Стратегийн тэргүүлэх чиглэл:

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дор дурдсан үйл ажиллагааны стратегийн тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

4.3.1. Мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, худалдаа үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх;

4.3.2. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, нөөцийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, бүртгэх, тэдгээрийг тогтвортой ашиглах, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэх;

4.3.3. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усан хангамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах;

4.3.4. Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, эрчимжүүлэх, таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, тариалангийн эдэлбэр газрыг эргэлтэд оруулах, хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.3.5. Байгалийн гэнэтийн аюул, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;

4.3.6. Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

4.3.7. Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, шим тэжээлийн зохистой хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах;

4.3.8. Мэдээллийн технологийн хөгжилд нийцүүлэн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан, шуурхай, ил тод байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх;

4.3.9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, тайлагналт, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ


5.1. Салбарын хүний нөөц

Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарт ажиллах боловсон хүчинг Улаанбаатар хотын ХААИС, Дархан-Уул аймаг дахь ХААИС-ын салбар, аймгийн Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд бэлтгэгдэж байна. 2024 оны эхээр салбарт 8517 боловсон хүчин ажиллаж байна. Энэ нь аймгийн нийт ажиллах хүчний 27.4 хувийг эзэлж байна.



МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД

Их, дээд сургуулийн суралцагчид



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ажиллах хүч:

Салбарууд	2020	2021	2022	2023
Аймгийн нийт ажиллах хүчний тоо	34419	30959	31850	31060
ХХААХҮ-ийн салбарын ажиллах хүч:	13751	10410	10312	8517
- Хөдөө аж ахуй	2976	2670	1879	1243
- Боловсруулах үйлдвэрлэл	4872	2573	3607	3383
-Худалдаа, үйлчилгээ	4901	4551	3632	3508
-Нийтийн хоолны үйлчилгээ	1002	616	1194	383
Нийт ажиллах хүчинд ХХААХҮ-ийн салбарын эзлэх хувь	40	33.6	32.4	27.4

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 4 хэлтэс, 23 албан хаагч ажиллаж байна. Үүнээс:

- Төрийн захиргааны албан хаагч 18,
- Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан хаагч 2,
- Төрийн үйлчилгээний албан хаагч 3 байна.

5.2. Санхүүгийн нөөц

Байгууллагын болон чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв

(сая төг)

№	Хөтөлбөр	2024	2025	2026	2027	2028
1	Байгууллагын батлагдсан төсөв	1,095.3	920.6	1,369.8	1,711.5	2,053.6
2	Мал аж ахуйн салбар	387.2	421.0	478.0	483.0	485.0
3	Хүнс, газар тариалангийн салбар	107.0	25.0	100.0	120.0	120.0
4	Өрхийн тариалан дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх	70.0	50.0	80.0	85.0	90.0
5	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбар	40.0	25.0	30.0	35.0	40.0
6	Хоршооны салбар	20.0	8.0	50.0	60.0	80.0
7	Ахуйн үйлчилгээний салбар	20.0	8.0	20.0	30.0	35.0
	Дүн	1,739.5	1,457.6	2,127.8	2,524.5	2,903.6

5.3. Мэдээллийн болон технологийн нөөц

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2018 оны 05 дугаар сараас И-Оффисс системийг ашиглан ХХААХҮЯ, аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, багууд, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай харилцдаг.

Орхон.Хүнс, хөдөө аж ахуйн газар байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хүргэн ажиллаж байна.

ХХААГ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг <https://hhaag.erdenet.mn/> цахим сайтаар нээлттэй ил тод мэдээлдэг.

5.3.1. Мэдээллийн цахим систем:

№	Байгууллагын нэр	Хаяг
1.	ХХААХҮЯ	https://www.mofa.gov.mn/
2.	ХХААГ	https://hhaag.erdenet.mn/
3.	Эрдэнэт и-оффис	https://eoffice.erdenet.mn/modules/main/
4.	ХХАА, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	https://rdc.gov.mn/
5.	Орхон аймгийн ЗДТГ	https://erdenet.mn/
6.	Хөдөө аж ахуйн бирж	https://mce.mn/
7.	Жижиг, дунд үйлдвэрийн газар	https://sme.gov.mn/
8.	Шилэн данс	https://shilendans.gov.mn/
9.	Шил ажиллагаа	https://shilen.gov.mn/
10.	Авлигатай тэмцэх газар	https://iaac.mn/
11.	Иргэдийн санал хүсэлт илгээх	https://irgen.erdenet.mn/
12.	Малын удмын сангийн үндэсний төв	https://genebank.gov.mn/
13.	Тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн систем	https://plant.mofa.gov.mn/
14.	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан	https://livestock.mofa.gov.mn/publicpage

5.4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

5.4.1. Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин				
			2024	2025	2026	2027	2028	
1	Малын тоо	мянган толгой	175.8	176.1	176.4	176.7	176.7	
2	Хураан авсан үр тариа	мянган тонн	12.1	10.5	11.0	11.2	11.5	
3	Хураан авсан төмс, хүнсний ногоо	мянган тонн	1.9	2.3	2.5	2.7	3.0	
